



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 05 сарын 18 өдөр

Дугаар 0/2015

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.1, 47.4 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 67 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн Өмчийг хувьчлах журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төв цэнгэлдэх хүрээлэн” ХХК-ийн нийслэлийн мэдлийн 49 хувь, Сүхбаатар дүүргийн Нэгдсэн эмнэлгийн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог хавсралт ёсоор баталсугай.

2. Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж ажиллахыг Үнэлгээний хороо /Д.Рэнцэнбямба/-нд үүрэг болгосугай.

3. Худалдан авах ажиллагаатай холбоотой баримт бичгийн архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга Б.Мөнгөнхүүд даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115050000531

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны ..05.. сарын 18.. –ний өдрийн ..0/215.. дугаар тушаалын хавсралт

Гүйцэтгэгч сонгон шалгаруулах
үнэлгээний хорооны бүрэлдэхүүн

Дарга	Д.Рэнцэнбямба	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын орлогч дарга
Гишүүд	Д.Итгэл	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн дарга
	Г.Сэлэнгэ	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/
	Д.Содномдорж	Баянгол дүүргийн 7 дугаар хороо, 3 дугаар хорооллын 69-37 тоотод оршин суугч иргэн /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга	Б.Мөнгөнхүү	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн мэргэжилтэн